



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 69

Хэрлэн сум

Батширээт сумын Соёлын төвийн даргын
сул орон тоонд томилуулахаар
нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 7.2, 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо (61) авч тэнцсэн Чимэддоржийн Болорцэцэгийг Батширээт сумын Соёлын төвийн даргын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Ч.Болорцэцэгийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Батширээт сумын Засаг дарга (Г.Гансүх)-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Батширээт сумын Засаг даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР